



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/33/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Аудитор: С.Энхбаатар

Утас: 70584207 Цахим хаяг: Enkhbaatars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15



1.Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 281

танай _____-ны № _____-т

Г ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.ЭНХЭЭ ТАНАА

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн захирагч 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хангалттай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020061



Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,703,000.00	5,228,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,703,000.00	5,228,000.00
354	Хангамжийн материал	3,703,000.00	5,228,000.00
35420	Аж ахуйн материал	3,703,000.00	3,998,000.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	1,230,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,942,881.39	27,957,072.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,942,881.39	27,957,072.74
392	Биет хөрөнгө	43,842,881.47	27,907,072.86
39203	Авто-тээврийн хэрэгсэл	135,000,000.00	120,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-110,000,000.19	-120,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,705,008.67	51,216,470.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,528,694.46	-27,607,449.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,060,958.00	17,302,958.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,394,390.55	-13,004,905.83
393	Биет бус хөрөнгө	99,999.92	49,999.88
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,250,000.08	-1,300,000.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	47,645,881.39	33,185,072.74
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	47,645,881.39	33,185,072.74
51	Засгийн газрын хувь оролцоо	47,645,881.39	33,185,072.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60,169,756.83	60,169,756.83
51101	Өмч: - төрийн	60,169,756.83	60,169,756.83
512	Хуримтлагдсан үр дүн	-15,947,143.44	-30,407,952.09
51210	Өмнөх үеийн үр дүн	-15,947,143.44	-15,947,143.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-14,460,808.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,423,268.00	3,423,268.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	47,645,881.39	33,185,072.74



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	802,310,700.00	4,025,975,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,310,700.00	4,025,975,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	367,861,100.00	3,577,900,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,361,100.00	900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	365,500,000.00	3,577,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,449,600.00	448,075,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,449,600.00	448,075,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	834,884,712.96	4,040,436,008.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	834,884,712.96	4,040,436,008.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	754,841,488.36	3,958,319,886.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,109,912.19	160,991,523.00
210101	Үндсэн цалин	130,233,912.19	156,632,054.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,196,000.00	4,359,468.51
210104	Урамшуулал	1,680,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,876,816.42	20,561,154.47
210201	Тэтгэврийн даатгал	11,493,476.42	13,981,587.47
210202	Тэтгэмжийн даатгал	1,345,835.00	1,644,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,076,667.00	1,315,914.00
210204	Ажилгүйдлийн даатгал	269,168.00	328,977.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,691,670.00	3,289,784.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,325,000.00	6,480,000.00
210301	Гэрэл, цахилгаан	960,000.00	880,000.00
210302	Түлш, халаалт	2,000,000.00	1,750,000.00
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	220,000.00
210304	Байрны түрээс	4,125,000.00	3,630,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,364,236.00	21,832,468.00
210401	Бичиг хэрэг	3,993,450.00	3,499,830.00
210402	Тээвэр, шатахуун	16,383,300.00	15,109,749.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,292,786.00	1,818,889.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	886,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,194,700.00	518,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,399,950.00	4,050,000.00
210604	Урсгал засвар	6,399,950.00	4,050,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,893,100.00	5,265,000.00
210702	Дотоод албан томилолт	16,394,000.00	5,265,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,499,100.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	130,920,489.00	125,543,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,394,589.00	125,181,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	140,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,900.00	178,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	410,951,984.75	3,613,595,760.65



210901	Бараа үйлчилгээний бусад зардал	369,856,400.00	3,568,189,952.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,272,550.00	12,450,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,823,034.75	32,955,808.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,043,224.60	82,116,122.53
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	68,000,000.00	66,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	68,000,000.00	66,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	11,452,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,382,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,070,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,043,224.60	4,663,822.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,043,224.60	4,663,822.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-32,574,012.96</u>	<u>-14,460,808.65</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-32,574,012.96</u>	<u>-14,460,808.65</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>802,310,700.00</u>	<u>4,025,975,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	802,310,700.00	4,025,975,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	367,861,100.00	3,577,900,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,361,100.00	900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	365,500,000.00	3,577,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	434,449,600.00	448,075,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	434,449,600.00	448,075,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>802,310,700.00</u>	<u>4,025,975,200.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	802,310,700.00	4,025,975,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,267,475.40	3,943,859,077.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,109,912.19	160,991,523.00
210101	Үндсэн цалин	130,233,912.19	156,632,054.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,196,000.00	4,359,468.51
210104	Урамшуулал	1,680,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,822,938.21	20,561,154.47
210201	Тэтгэврийн даатгал	11,439,598.21	13,981,587.47
210202	Тэтгэмжийн даатгал	1,345,835.00	1,644,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,076,667.00	1,315,914.00
210204	Ажилгүйдлийн даатгал	269,168.00	328,977.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,691,670.00	3,289,784.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,325,000.00	6,480,000.00
210301	Гэрэл, цахилгаан	960,000.00	880,000.00
210302	Түлш, халаалт	2,000,000.00	1,750,000.00
210303	Цэвэр, бохир ус	240,000.00	220,000.00
210304	Байрны түрээс	4,125,000.00	3,630,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,187,236.00	22,127,468.00
210401	Бичиг хэрэг	3,113,450.00	3,499,830.00



210402	Тээвэр, шатахуун	16,383,300.00	15,109,749.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,292,786.00	1,818,889.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	886,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,897,700.00	813,000.00
2105	Нормативт зардал	00.00	1,230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,399,950.00	11,530,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	6,600,000.00
210602	Тавилга	00.00	880,000.00
210604	Урсгал засвар	6,399,950.00	4,050,000.00
2107	Томилолт, зочны зардал	18,893,100.00	5,265,000.00
210702	Дотоод албан томилолт	16,394,000.00	5,265,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,499,100.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	130,400,389.00	125,543,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,874,489.00	125,181,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	140,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,900.00	178,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	377,128,950.00	3,590,129,952.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	369,856,400.00	3,577,679,952.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,272,550.00	12,450,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,043,224.60	82,116,122.53
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	68,000,000.00	66,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	68,000,000.00	66,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	11,452,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	10,382,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,070,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,043,224.60	4,663,822.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,043,224.60	4,663,822.53
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,742,768.00	26,016,346.71	00.00	89,928,871.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,169,756.83	3,742,768.00	26,016,346.71	00.00	89,928,871.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,687,834.10	00.00	33,687,834.10
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-15,947,143.44	00.00	47,645,881.39
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-15,947,143.44	00.00	47,645,881.39
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-15,947,143.44	00.00	47,645,881.39
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,460,808.65	00.00	-14,460,808.65
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,169,756.83	3,423,268.00	-30,407,952.09	00.00	33,185,072.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

		/ төгрөгөөр /	
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	448,075,200.00	443,433,425.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,075,200.00	443,433,425.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,604,600.00	365,981,125.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,340,000.00	160,991,523.00
210101	Үндсэн цалин	153,700,000.00	156,632,054.49
210102	Нэмэгдэл	00.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,640,000.00	4,359,468.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,062,700.00	20,561,154.47
210201	Тэтгэврийн даатгал	14,483,100.00	13,981,587.47
210202	Тэтгэмжийн даатгал	1,644,900.00	1,644,892.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,316,300.00	1,315,914.00
210204	Ажилгүйдлийн даатгал	328,600.00	328,977.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,289,800.00	3,289,784.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,480,000.00	6,480,000.00
210301	Гэрэл, цахилгаан	880,000.00	880,000.00
210302	Түлш, халаалт	1,750,000.00	1,750,000.00
210303	Цэвэр, бохир ус	220,000.00	220,000.00
210304	Байрны түрээс	3,630,000.00	3,630,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,759,000.00	22,127,468.00
210401	Бичиг хэрэг	3,220,000.00	3,499,830.00
210402	Тээвэр, шатахуун	16,840,000.00	15,109,749.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	1,818,889.00
210404	Ном, хэвлэл	886,000.00	886,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	813,000.00	813,000.00
2105	Нормативт зардал	1,230,000.00	1,230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,230,000.00	1,230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,530,000.00	11,530,000.00



210601	Багаж, техник, хэрэгсэл	6,600,000.00	6,600,000.00
210602	Тавилга	880,000.00	880,000.00
210604	Урсгал засвар	4,050,000.00	4,050,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,123,000.00	5,265,000.00
210702	Дотоод албан томилолт	6,123,000.00	5,265,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,147,900.00	124,643,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,782,000.00	124,281,980.00
210803	Даатгалын үйлчилгээ	140,000.00	140,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	181,900.00	178,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16932000.00	13152000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,202,000.00	702,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,730,000.00	12,450,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77470600.00	77452300.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	66,000,000.00	66,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	66,000,000.00	66,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,470,600.00	11,452,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,382,300.00	10,382,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,088,300.00	1,070,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	448,075,200.00	448,075,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	448,075,200.00	448,075,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	448,075,200.00	448,075,200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		
620001	Удирдах ажилтан		
620002	Гүйцэтгэх ажилтан		
620003	Үйлчлэх ажилтан		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

			/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,577,877,952.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,577,877,952.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,577,877,952.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		900,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3576977952.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,576,977,952.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	3,577,900,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		3,577,900,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		900,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,577,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Энхээ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Энхбаатар хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн ИТХ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймагт дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 2/17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорнод аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн шууд захирагч санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд Аймгийн ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 4,040,436.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 80,808.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймгийн ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14,460.8 мянган төгрөгөөр буюу 30.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	3,703.0	5,228.0	1,525.0
Үндсэн хөрөнгө	43,942.9	27,957.1	-15,985.8
Нийт хөрөнгө	47,645.9	33,185.1	-14,460.8
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	47,645.9	33,185.1	-14,460.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	47,645.9	33,185.1	-14,460.8

Бараа материалын дансны үлдэгдэл 5,228.0 мянган төгрөг болж 1,525.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,957.1 мянган төгрөг болж 15,985.8 мянган төгрөгөөр буурсан нь тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталснаас шалтгаалжээ. Биет бус хөрөнгө нэмэгдэж, хасагдаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 33,185.1 мянган төгрөг болж 14,460.8 мянган төгрөгөөр буурсан нь үйл ажиллагааны үр дүн буурснаас шалтгаалжээ

Аймгийн ИТХ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,223,664.5 мянган төгрөгөөр өссөн нь цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос хуваарилсан орлогоос шалтгаалжээ.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 3,211,500.0 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 3,205,551.3 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 535,704.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 535,704.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 87,629.6 мянган төгрөгөөр бууруулж 448,075.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 448,075.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 448,075.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 448,075.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 443,433.4 мянган төгрөгийг зарцуулж, 4,641.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 443,433.4 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссоос 3,562,000.0 мянга, бусад 15,900.0 мянга, нийт 3,577,900.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний бусад зардалд бүрэн зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147, хугацаа болоогүй 2 мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,586,382.3 мянган төгрөгийн зарлагын 45 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэмжлэл өгсөн тул төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,656,518.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,500.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,654,018.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд 2,500.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан боловч данснаас хасаагүйд залруулга хийлгэв.



Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 3,654,018.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,586,382.3 мянган төгрөгийн зарлагын 45 мэдээллийг огт байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2. Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байхад аймгийн ИТХ-д суудалтай намуудад 66,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон нь Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т заасан орон нутаг өөрийн төсвөөр бие даан санхүүжүүлэх чиг үүрэгт тухайлан заагдаагүй, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Улсын их хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна.” гэсэн заалт нь орон нутагт хамааралгүй байна. Санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Томилолтын зардлаас анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,636.0 мянган төгрөгийг гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй гэж үзлээ.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/33/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн ИТХ		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,586,382.3 мянган төгрөгийн зарлагын 45 мэдээллийг огт байршуулаагүй байна.	3,586,382.3	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Энхээ Д.Баттулга
2	Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох тухай хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байхад аймгийн ИТХ-д суудалтай намуудад 66,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.	66,000.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Энхээ Д.Баттулга
3	Томилолтын зардлаас анхан шатны баримтын бүрдэл дутуу 1,636.0 мянган төгрөгийг гаргасан байна.	1,636.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Энхээ Д.Баттулга
4	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 21 дүгээр тогтоолоор тус байгууллагын 21 ширхэг 17,216.5 мянган төгрөгийн хөрөнгүүдийг акталсан боловч 1 ширхэг 2500.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс, бүртгэлээс хасаагүй байна.	2,500.0	Залруулсан	Дарга, Нягтлан бодогч	Б.Энхээ Д.Баттулга
ДҮН		3,656,518.3			

